



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Баянхонгор-Эрчим хүч ЦТ” ХХК-ийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БНА-2023/1/НА-СТА-ОНӨААН

Цахим хуудас: www.audit.mn

Баянхонгор
2023 оны 03 дугаар сарын 20

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат
Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn
Аудитын менежер: А.Цээням
Утас: 70442424 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn
Аудитор: Н.Батчимэг
Утас: 91113253 Цахим хаяг: batchimegn@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан	5
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	6
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	6
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	6
Дотоод хяналт	7
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	7
3.4 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, тодруулгад гарсан өөрчлөлтүүд.....	7
4. Аудитын тайлан	10
4.1 Ерөнхий зүйл	10
4.2 Материаллаг байдал	11
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	11
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	11
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	12
4.5.1 Завсрын аудитын талаар	12
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	12
5. Аудитын илрүүлэлт.....	12
Залруулсан алдаа	12
5.3 Зөвлөмж.....	12
6. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	0

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ЦТХХК	Цахилгаан түгээх хариуцлагатай хувьцаат компани
ДҮТ	Диспичерийн үндэсний төв



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584
Цахим шуудан: procurement_bayankhongor@audit.gov.mn

2023.03.20 № 2/100
танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Баянхонгор-Эрчим хүч” ЦТХХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

“Баянхонгор-Эрчим хүч” ЦТХХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар тодорхой бус байдал нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Тайлант онд хөрөнгө оруулалтын ажлын төлөвлөгөөнд өндөр хүчдэлийн туршилт, тоолуур хэмжих хэрэгслийн лабораторийн барилга барих ажлыг 618,708.9 мянган төгрөгийн төсөвт өртөгтэйгөөр төсөвлөж 2 удаа тендер зарлан оролцогч ороогүй тул шууд гэрээгээр “Ингүмэл Дөл” ХХК-тай 2022 оны 7 дугаар сарын 08-ны өдөр ажил гүйцэтгүүлэх гэрээ байгуулж барилгын ажлыг гүйцэтгэсэн, улсын комисс хүлээн аваагүй тул хөрөнгийг дуусаагүй барилга дансанд бүртгэсэн байна.

Авлага дансны үлдэгдэл 1,277,172.1 мянган төгрөг болж 988,336.4 мянган төгрөгөөр өссөн нь тайланд онд цахилгаан эрчим хүчний бичилтийн циклд өөрчлөлт

005020473

орж 12 дугаар сарын 31-нээр тасалбар болгон авлагыг бүртгэснээс 957,125.0 мянга, цахилгааны авлага, шөнийн тарифын авлага, компани хоорондын авлага 341,252.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй, найдваргүй авлагын хасагдуулаг дансыг 21,205.5 мянган төгрөгөөр тус тус бүртгэсэн байна.

Дэлхийн банкны 493,330.0 мянга, Азийн хөгжлийн банкны 15,711.0 мянган төгрөгийн урт хугацаат зээлийн өртэй байна.

Эрчим хүчний зохицуулах хорооны 2022.12.15-ны өдрийн “Тарифт өөрчлөлт оруулах тухай” 632 дугаар тогтоолоор цахилгааны төлбөрт өөрчлөлт орсон, мөн бичилтийн цикл өөрчлөгдсөнөөс шалтгаалж Диспетчерийн Үндэсний төв 273,147.9 мянга, МҮОНТ-д 8,269.3 мянга, “Цэвэр хот” ОНӨААТҮГ болон 7 сумын хог хаягдлын хураамжийн орлогын 138,308.9 мянга, татварын өглөг 154,038.0 мянга, урьдчилж орсон орлого 17,873.8 мянга, нийт 1,100,678.9 мянган төгрөгийн өглөгтэй байна.

Бусад асуудлын хэсэг

“Баянхонгор-Эрчим хүч” ЦТХХК-ийн 2022 оны жилийн эцсийн ажлын гүйцэтгэлийг Төлөөлөн удирдах зөвлөлөөс хангалттай сайн гэж үнэлсэн байна.

“Баянхонгор-Эрчим хүч” ЦТХХК-ийн 2022 оны 2022 оны санхүүгийн тайланд толилууаагүй, тодруулаагүй асуудал байхгүй, аудитад ажил гүйлгээг түүврийн аргыг ашиглан гүйцэтгэсэн болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Б.МӨНХБАТ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
А	Б	1	2
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	460,083,423.49	49,240,603.18
1.1.2	Дансны авлага	192,934,215.29	1,159,818,927.74
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	462,726.04	(0.00)
1.1.4	Бусад авлага	95,438,720.87	117,353,207.01
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	-	-
1.1.6	Бараа материал	296,995,962.02	394,208,050.25
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	275,180,030.42	126,692,280.16
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	1,321,095,078.13	1,847,313,068.35
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	19,071,285,328.02	18,637,580,197.60
1.2.2	Биет бус хөрөнгө	449,266,600.93	460,904,475.83
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	-	615,454,398.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	19,520,551,928.95	19,713,939,071.43
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	20,841,647,007.08	21,561,252,139.77
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	6,812.42	419,726,110.73
2.1.1.2	Цалингийн өглөг	31,932.01	0.00
2.1.1.3	Татварын өр	42,233,987.22	154,037,984.28
2.1.1.4	НДШ-ийн өглөг	14.09	23.47
2.1.1.5	Богино хугацаат зээл	40,579,284.96	-
2.1.1.6	Хүүгийн өглөг	-	-
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	-	-
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	25,439,968.42	17,873,770.42
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	108,291,999.12	591,637,888.90
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	504,553,475.07	509,040,998.95
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	504,553,475.07	509,040,998.95
2.2	Өр төлбөрийн нийт дүн	612,845,474.19	1,100,678,887.85
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч: - төрийн	1,426,737,382.97	1,426,737,382.97
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	5,027,341,582.02	5,027,341,582.02
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	16,116,347,100.71	16,125,737,100.71
2.3.9	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	(2,341,624,533.06)	(2,119,242,814.09)
2.3.11	Эздийн өмчийн дүн	20,228,801,532.64	20,460,573,251.61
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	20,841,647,006.83	21,561,252,139.46

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
1	Борлуулалтын орлого (цэвэр)	11,264,528,073.52	12,377,877,436.16
2	Борлуулалтын өртөг	8,297,027,321.20	8,569,229,813.15
3	Нийт ашиг (алдагдал)	2,967,500,752.32	3,808,647,623.01
5	Хүүгийн орлого	2,102,340.91	95,454.54
8	Бусад орлого	279,054,932.36	673,617,362.56
9	Борлуулалт, маркетингийн зардал	643,023,567.32	701,211,490.36
10	Ерөнхий ба удирдлагын зардал	2,746,411,193.35	2,963,136,615.43
11	Санхүүгийн зардал	6,195,909.12	10,219,617.98
12	Бусад зардал	268,606,293.97	557,498,126.21
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	(3,203,791.33)
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(415,578,938.17)	247,090,798.81
19	Орлогын татварын зардал	210,234.09	24,709,079.89
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(415,789,172.26)	222,381,718.92
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(415,789,172.26)	222,381,718.92
24	Орлогын нийт дүн	(415,789,172.26)	222,381,718.92
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	0.00	0.00

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	Нийт дүн
2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,426,737,382.97	5,027,341,582.02	15,801,335,459.53	(1,925,835,360.80)	20,329,579,063.72
Залруулсан үлдэгдэл	1,426,737,382.97	5,027,341,582.02	15,801,335,459.53	(1,925,835,360.80)	20,329,579,063.72
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	(415,789,172.26)	(415,789,172.26)
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	315,011,641.18	-	315,011,641.18
2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,426,737,382.97	5,027,341,582.02	16,116,347,100.71	(2,341,624,533.06)	20,228,801,532.64
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	0.05	0.05
Залруулсан үлдэгдэл	1,426,737,382.97	5,027,341,582.02	16,116,347,100.71	(2,341,624,533.01)	20,228,801,532.69
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	222,381,718.92	222,381,718.92
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	9,390,000.00	-	9,390,000.00
2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,426,737,382.97	5,027,341,582.02	16,125,737,100.71	(2,119,242,814.09)	20,460,573,251.61

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	9,786,169,865.45	11,197,804,569.30

	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	3,697,294,391.91	8,281,490,951.34
	Бусад мөнгөн орлого	6,088,875,473.54	2,916,313,617.96
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	9,726,979,684.65	11,276,062,281.40
	Ажиллагчдад төлсөн	1,138,650,105.46	1,278,167,465.97
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	357,442,670.39	444,073,866.93
	Бараа материал худалдан авахад төлсөн	4,137,376,312.54	4,790,469,787.32
	Ашиглалтын зардалд төлсөн	51,940,185.60	100,600,681.42
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	37,608,502.00	57,602,458.00
	Татварын байгууллагад төлсөн	170,546,976.88	263,270,666.41
	Даатгалын төлбөрт төлсөн	10,013,299.66	4,759,040.00
	Бусад мөнгөн зарлага	3,823,401,632.12	4,337,118,315.35
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	59,190,180.80	(78,257,712.10)
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	4,350,000.00
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	4,350,000.00
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	215,092,638.00	336,935,108.21
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	204,446,838.00	308,877,608.21
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	10,645,800.00	28,057,500.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(215,092,638.00)	(332,585,108.21)
4.2	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(155,902,457.20)	(410,842,820.31)
5.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	615,985,880.69	460,083,423.49
5.2	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	460,083,423.49	49,240,603.18

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

“Баянхонгор-Эрчим хүч” ЦТХХК-ийн зорилго нь “Стандартын цахилгаан эрчим хүчээр хангах, түгээх, борлуулах үйл ажиллагаанд шинэ дэвшилтэт техник технологийг нэвтрүүлж сүлжээний алдагдлыг багасган хэрэглэгчдийг тасралтгүй найдвартай цахилгаан эрчим хүчээр хангаж, мэргэшсэн чадварлаг боловсон хүчнээр соёлтой, чанартай үйлчилгээг үзүүлж, шударга харилцааг эрхэмлэн ажиллах”-д оршино.

Тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг “Эрдэнэт, Булган, Хархорин Өвөрхангай аймгийн 110кВ-н цахилгаан дамжуулах агаарын шугамаар цахилгаан эрчим хүч дамжуулан авч хэрэглэгчдэд түгээх” гэж тодорхойлжээ.

Тус газар нь цахилгаан шугам сүлжээ шуурхай үйлчилгээний алба, хэрэглэгчдэд үйлчлэх төв, захиргаа аж ахуйн гэсэн 3 алба хэсэгтэй, 94 орон тоотой үйл ажиллагаа явуулсан байна.

Тайлант онд хөрөнгө захиран зарцуулах нэгдүгээр гарын Захирал Ж.Уламбаяр, хоёрдугаар гарын үсгийг ерөнхий нягтлан бодогч Б.Хорлоо (2022.01.01-2022.02.28, 2022.09.01.-2022.12.31), нягтлан бодогч О.Ууганбаяр (2022.03.01-2022.08.31) нар зурж нярваар Ц.Ганцэцэг ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн 1965 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн 154 тоот тогтоолд аймгуудын эрчим хүчний газрыг 1965-1967 онд багтаан байгуулахаар заасны дагуу 1966 оны 04 дүгээр сарын 01-нд Баянхонгор аймгийн төвд Эрчим хүчний үйлдвэр анх байгуулагдсан бөгөөд аймгийн ИТХ-ын 2002 оны 78 дугаар тогтоолоор 100 хувь орон нутгийн өмчит “Баянхонгор-Эрчим хүч” ЦТХХК болон өөрчлөгдөн зохион байгуулагджээ.

Монгол Улсын Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно.” гэж заасан байна. Энэ хүрээнд Аймгийн Засаг Даргын 2021-2024 оны мөрийн хөтөлбөрт “Аймаг, сумын төвүүдийн 380/04кВ-ын шугамын өргөтгөлийг хэрэгцээ шаардлагын дагуу нэмэгдүүлж гудамж талбайн гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх, аймгийн төвд 35/10кВ-ын дэд станц шинээр байгуулан албан байгууллага, айл өрхүүдийг шөнийн тарифт, ухаалаг тоолуурт шилжүүлэх” тухай заалт тусгуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна.

- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж эхэлсэн.
- Засгийн газрын 2022 оны 120 дугаар тогтоолоор албан томилолтын зардлын тариф өөрчлөгдсөн.

Дотоод хяналт

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус байгууллагын бүтцэд дотоод хяналтын ажилтан гүйцэтгэх удирдлагын шууд удирдлагад ажиллаж байгаа ба дотоод хяналт шалгалтын төлөвлөгөөг гүйцэтгэх захирлаар батлуулан ажиллаж, тайлант онд нийт 13 албан тушаалтанд алдаа, зөрчлийг арилгах 73 зөвлөмж өгч хэрэгжилтийг тооцож ажилласан байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

“Баянхонгор-Эрчим хүч” ЦТХХК-ийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, тодруулгад гарсан өөрчлөлтүүд

“Баянхонгор-Эрчим хүч” ЦТХХК-ийн санхүүгийн тайлан нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

“Баянхонгор-Эрчим хүч” ЦТХХК-ийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө 21,561.4 мянган төгрөг байгаа бөгөөд өмнөх оноос 719.8 мянган төгрөгөөр буюу 3.4 хувиар хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
A	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,321,095.1	1,847,313.1	526,218.0
Мөнгөн хөрөнгө	460,083.4	49,240.6	(410,842.8)
Авлага	288,835.7	1,277,172.1	988,336.4
Урьдчилгаа	275,180.0	126,692.3	(148,487.7)
Бараа материал	296,996.0	394,208.0	97,212.0

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	19,520,551.9	19,713,939.0	193,387.1
Үндсэн хөрөнгө	28,488,770.0	29,048,657.7	559,887.7
Хуримтлагдсан элэгдэл	(9,417,484.7)	(10,411,077.5)	(993,592.8)
Биет бус хөрөнгө	520,048.8	545,091.9	25,043.1
Хуримтлагдсан элэгдэл	(70,782.2)	(84,187.4)	(13,405.2)
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	0	615,454.4	615,454.4
Нийт хөрөнгө	20,841,647.0	21,561,252.1	719,605.1
Нийт өр төлбөр	612,845.5	1,096,787.1	485,032.6
Богино хугацаат өр төлбөр	108,292.0	591,637.9	483,436
Урт хугацаат өр төлбөр	504,553.5	509,040.9	4,487.4
Эздийн өмч	20,228,801.5	20,460,573.2	231,771.7
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	20,841,647.0	21,561,252.1	719,605.1

Эх сурвалж: 2022 оны санхүүгийн тайлан

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 49,240.6 мянган төгрөг болж 410,842.8 мянган төгрөгөөр буурсан нь тарифын үнэ өссөнтэй холбоотойгоор ДҮТ-д шилжүүлэх төлбөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Авлага дансны үлдэгдэл 1,277,172.1 мянган төгрөг болж 988,336.4 мянган төгрөгөөр өссөн нь тайланд онд цахилгаан эрчим хүчний бичилтийн циклд өөрчлөлт орж 12 дугаар сарын 31-нд бичилт хийж тухай авлага төлөгдөх хугацаагүйгээс 957,125.0 мянган төгрөгийн авлага үүссэн нь авлага нэмэгдэх гол шалтгаан болсон байна.

Урьдчилгаа дансны үлдэгдэл 126,692.2 мянган төгрөг болж өмнөх оноос 148,487.7 мянган төгрөгөөр буурсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 394,208.0 мянган төгрөг болж 37,672.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь 1,092,940.3 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан, 90,907.2 мянган төгрөгийн бараа материал борлуулсан, 901,459.1 мянган төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаандаа зарцуулсан, 3,361.7 мянган төгрөгийн бараа материалыг акталсантай холбоотойн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 29,048,687.7 мянган төгрөг болж 559,887.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд их засвар техник зохион байгуулалтын арга хэмжээний зардалд тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлж 578,917.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэн бүртгэсэн, аймгийн ИТХ-ын тогтоолоор 19,000.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө акталсантай холбоотой байна.

Биет бус хөрөнгө дансны үлдэгдэл 545,091.9 мянга болж өмнөх оноос 25,043.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь шугамын алдагдлын тооцоо боддог программ, утсан дээр суурилуулдаг бичилтийн аппликейшн зэргийг худалдан авч бүртгэсэнтэй холбоотой байна.

Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө дансны үлдэгдэл 615,454.4 мянган төгрөг болж нэмэгдсэн нь 2022 оны хөрөнгө оруулалтын ажлын төлөвлөгөөнд өндөр хүчдэлийн туршилт, тоолуур хэмжих хэрэгслийн лабораторийн барилга барих ажлыг 618,708.9 мянган төгрөгийн төсөвт өртөгтэйгээр төсөвлөж 2 удаа тендер зарлан оролцогч ороогүй бөгөөд 2022.06.10-ны өдөр Тендерийн үнэлгээний хорооноос шууд гэрээ байгуулахыг зөвлөсний дагуу 2022.07.08-ны өдөр “Ингүмэл Дөл” ХХК-тай ажил гүйцэтгүүлэх гэрээ байгуулж барилгын ажил дууссан байна. Барилгыг хүлээн авах ажлын хэсэг ажиллаагүй байгаа тул хөрөнгийг дуусаагүй барилга дансанд бүртгэсэн байна.

Богино хугацаат өр төлбөр өмнөх оноос 524,520.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант онд хувь хүний орлогын албан татвартай холбоотой 220.1 мянга, нэмэгдсэн өртгийн албан татвартай холбоотой 131,971.6 мянга, аж ахуйн нэгжийн орлогын албан татвартай холбоотой 18,232.8 төгрөгийн өр үүссэнийг бүртгэж, урт хугацаат зээлийн 2023 онд төлөгдөх үндсэн зээлийн төлбөр болох 40,579.3 мянган төгрөгийг богино хугацаат өр төлбөрөөр бүртгэсэнтэй холбоотой байна.

Урт хугацаат өр төлбөрийн үлдэгдэл 81,158.6 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд 40,579.3 мянган төгрөгийн зээлийн төлбөр төлөгдсөн, мөн 2023 онд төлөгдөх үндсэн зээлийн төлбөрийг богино хугацаат өр төлбөрөөр шилжүүлж бүртгэсэнтэй холбоотой байна.

Эздийн өмч дансны үлдэгдэл 20,464,611.5 мянган төгрөг болж 235,810 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны үр дүн 226,420.0 мянган төгрөгөөр өсөж өмч хамгаалах байнгын зөвлөлийн шийдвэрээр 9,390.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй хүлээн авч эздийн өмчийг нэмэгдүүлсэн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

3.5. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу “Баянхонгор-Эрчим хүч” ЦТХХК нь үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

“Баянхонгор-Эрчим хүч” ЦТХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь тус компанийн 2022 оны орлого, зарлагын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 13,404,599.2 мянган төгрөгөөр, нийт зардлыг 13,404,599.2 мянган төгрөгөөр нийт ашиг алдагдлыг 0 төгрөг байхаар батлагдсан байна.

Гүйцэтгэлээр 13,055,544.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 12,803,966.5 мянган төгрөгийн зардал гаргаж 226,460.0 мянган төгрөгийн ашигтай ажилласан байна.

Тус компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 02 дугаар тогтоолоор 2022 оны тус байгууллагын үйл ажиллагааны зардлыг 2,974,534.4 мянган төгрөгөөр баталсан бөгөөд гүйцэтгэлээр 2,449,434.2 мянган төгрөгийг зарцуулж, 334,667.6 мянга буюу нийт зардлын 11.2 хувийг хэмнэж ажилласан байна.

Хүснэгт 2. 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин

(мянган төгрөг)

№	Зардлын төрөл	Мөрийн дугаар	Өмнөх оны мөн үеийн гүйцэтгэл	Тайлант оны		Өөрчлөлт	
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Өмнөх оноос	Төлөвлөгөөнөөс
	ХАЦЭХ		8,297,027.3	8,498,356.2	8,569,229.8	(272,202.5)	(70,873.6)
1	Шатахууны зардал	1	39,572.3	52,028.6	38,579.0	993.2	13,449.5
2	Тээврийн зардал	2				-	-
3	Сэлбэг хэрэгсэл	3	33,832.5	43,048.0	38,667.7	(4,835.2)	4,380.3
4	Урсгал засвар	4	76,381.1	95,350.0	87,083.7	(10,702.6)	8,266.3
5	Материал, хангамжийн материал	5	-	-	176.1	(176.1)	(176.1)
6	Үндсэн ба нэмэгдэл цалин, урамшуулал	6	1,320,812.4	1,809,221.9	1,526,402.7	(205,590.3)	282,819.2
7	Байгууллагаас төлөх ЭМ, НДШ	7	202,555.8	280,429.4	230,549.8	(27,994.0)	49,879.6
8	Ашиглалтын зардал-Цахилгаан	8	9,742.3	11,172.7	12,698.6	(2,956.3)	(1,525.9)
9	Ашиглалтын зардал-Дулаан	9	90,780.0	105,937.6	93,128.6	(2,348.6)	12,809.0
10	Ашиглалтын зардал-Ус	10	3,425.0	4,479.7	4,846.8	(1,421.8)	(367.1)
11	Албан томилолтын зардал	11	9,470.5	11,288.0	8,166.2	1,304.3	3,121.8
12	Конторын хангамжийн зардал	12	3,821.1	5,986.0	3,572.6	248.6	2,413.4
13	Харилцаа холбооны зардал	13	3,692.7	11,105.1	5,293.6	(1,600.9)	5,811.5
14	Харуул хамгаалалтын зардал	14	23,631.9	25,200.0	23,881.9	(250.0)	1,318.1
15	Хөдөлмөр хамгааллын зардал	15	26,383.4	95,948.0	40,379.8	(13,996.4)	55,568.2
16	Даатгалын зардал	16	13,560.4	13,516.2	13,580.6	(20.1)	(64.4)
17	Галын аюулаас хамгаалах зардал	17	-	3,000.0	-	-	3,000.0
18	Гүйцэтгэх удирдлагын зардал	18	181,435.7	247,824.2	215,808.6	(34,372.9)	32,015.6
19	Төлөөлөн удирдах зөвлөлийн зардал	19	30,097.9	45,056.4	42,620.4	(12,522.5)	2,436.0

“Баянхонгор-Эрчим хүч ЦТ” ХХК-ийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

20	Хяналтын зөвлөлийн зардал	20	-	-	-	-	-
21	Борлуулалт, маркетингийн зардал	21	5,489.4	19,000.0	7,970.1	(2,480.6)	11,029.9
22	Диспетчерийн зардал	22	-	-	-	-	-
23	Зохицуулалтын үйлчилгээний хөлс	23	9,070.0	10,609.0	9,300.0	(230.0)	1,309.0
24	Гаднын үйлчилгээний хөлс	24	15,789.0	18,471.3	18,247.1	(2,458.0)	224.2470
25	Түрээсийн зардал	25	-	-	-	-	-
26	Сургалтын зардал	26	7,610.8	23,443.0	21,396.3	(13,785.5)	2,046.7
27	Найдваргүй авлагын зардал	27	3,409.4	3,377.2	2,840.8	568.6	536.3528
28	Үйл ажиллагааны бусад зардал	28	1,277.7	1,242.2	1,317.9	(40.2)	(75.7)
29	Гамшгаас хамгаалах зардал		24,732.1	37,800.0	2,925.3	-	-
	Үйл ажиллагааны зардлын дүн	29	2,136,573.4	2,974,534.4	2,449,434.2	(334,667.6)	490,225.5
30	Ерөнхий хэрэглээний үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал	30	182,865.7	257,341.7	197,028.5	(14,162.8)	60,313.2
31	Үйлдвэрлэлийн зориулалттай үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал	31	838,122.5	1,026,275.3	821,811.3	16,311.2	204,464.0
	Элэгдлийн зардлын дүн	32	1,020,988.2	1,283,617.0	1,018,839.8	2,148.4	264,777.2
32	Үл хөдлөх хөрөнгийн татвар	33	13,790.5	13,353.7	9,491.8	4,298.6	3,861.9
33	АТӨЯХ-ийн албан татвар	34	753.5	1,127.6	877.5	(124.0)	250.1
34	Газрын төлбөр	35	498.8	4,143.3	869.1	(370.4)	3,274.2
35	Бусад татвар хураамж	36	-	-	2,021.9	(2,021.9)	(2,021.9)
	Орлогын албан татвараас бусад татварын дүн	37	15,042.8	18,624.6	13,260.4	1,782.4	5,364.3
36	Хүүгийн зардал-Урт хугацаат зээл	39	6,195.9	46,276.5	5,732.1	463.8	40,544.4
37	Ажиллагсдын нийгмийн зардал	40	230,620.9	225,185.7	192,305.6	38,315.3	32,880.1
	Хөрөнгө оруулалтын өгөөжөөр нөхөгдөх зардлын дүн	41	236,816.8	271,462.2	198,037.7	38,779.1	73,424.5
38	Үйл ажиллагааны бус зардал	42	254,815.8	230,079.5	555,164.6	(300,348.8)	(325,085.1)
39	Валютын ханшны алдагдал	43	-	-	-	-	-
	НИЙТ ЗАРДАЛ /29+32+37+41+42+43/	45	11,961,264.3	13,276,674.0	12,803,966.5	(864,509.0)	437,832.8
40	Борлуулалтын орлого	46	8,552,340.9	8,953,180.0	9,761,438.2	(1,209,097.4)	(808,258.2)
41	Түгээх үйлчилгээ орлого		2,712,187.2	4,093,414.5	2,616,439.2	-	-
42	Бусад орлого	48	281,157.0	230,079.5	677,666.9	(396,509.9)	(447,587.4)
	НИЙТ ОРЛОГО /46+47-45/	49	11,545,685.1	13,276,674.0	13,055,544.3	(1,605,607.2)	(1,255,845.6)
43	ТАТВАРЫН ДАРААХ АШИГ/АЛДАГДАЛ	50	(415,579.2)	0.0	226,420.0	-	-

Эх сурвалж: “Баянхонгор-Эрчим хүч” ЦТХХК-ийн 2022 оны орлого, зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл

4. Аудитын тайлан

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу “Баянхонгор-Эрчим хүч” ЦТХХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар

илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Н.Батчимэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цээням, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

“Баянхонгор-Эрчим хүч” ЦТХХК-ийн 2022 оны санхүүгийн тайланг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 06 тоот албан бичгээр ирүүлсэн.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 0.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн тайлангийн нийт зардал 9,786,169.9 мянган төгрөгөөс 0.5 хувиар буюу 48,930.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 34,251.6 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тухайн байгууллага нь төрийн тусгай чиг үүрэг хэрэгжүүлдэг байгууллага тул орон тооны болон тээврийн хэрэгслийн хязгаарлалт үйлчлэхгүй бөгөөд бусад хэмнэлттэй холбоотой заалтуудыг зөрчөөгүй болно.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь 2022 онд 77 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 66 мэдээллийг хугацаанд нь байршуулсан, 9 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 2 мэдээллийг байршуулах хугацаа болоогүй байна.

Тайлант онд шатахуун, бетон тулгуурын материал нийлүүлэх, өндөр хүчдэлийн туршилт, тоолуур хэмжих хэрэгслийн лабораторийн барилга, тоноглолын материал нийлүүлэх, трансформатор нийлүүлэх 5 гэрээний 1,152,163.8 мянга, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 10,869,546.2 мянган төгрөгийн 42 гүйлгээ, хүний нөөц, өмч хөрөнгө, санхүүтэй холбоотой 28 шийдвэрийн мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн мэдээлсэн байна.

Харин шилэн дансны нэгдсэн цахим хуудаст цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 60,852.2 мянган төгрөгийн 8 гүйлгээг хугацаа хоцорч мэдээлсэн байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль

тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Аудитаар нийт 57,139.1 мянган төгрөгийн 6 алдаа, зөрчил илэрснээс, 41,852.2 мянган төгрөгийн 3 алдааг санхүүгийн тайланд залруулж, 1,980.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 13,306.9 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргуулахгүй байх 2 зөвлөмж өгсөн.

Хүснэгт 5. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	1,980.0	1	1,980.0	100
Зөвлөмж	2	13,306.9	2	13,306.9	100
Нийт дүн	3	15,286.9	3	15,286.9	100

Аудитаар тогтоосон актын төлбөрийг барагдуулсан, зөвлөмжийг хэрэгжүүлсэн талаар тус байгууллагын 2022 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн 136 тоот албан бичгээр ирүүлснийг биелэлтийг тооцож FAS системд оруулсан байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тайлант онд 618,709.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй лабораторийн барилгыг барих тендерийг 2 удаа зарласан ч оролцогч оролцоогүй тул тендерийн үнэлгээний хорооны зөвлөсний дагуу “Ингүмэл Дөл” ХХК-тай ажил гүйцэтгүүлэх гэрээ байгуулж барилгын ажил дууссан байна. Барилгыг хүлээн авах ажлын хэсэг ажиллаагүй байгаа тул хөрөнгийг дуусаагүй барилга дансанд бүртгэсэн, хяналтыг хэн хэрэгжүүлэх талаар гэрээнд тусгаагүй, зураг төсвийн 8,200.0 мянга, хяналтын зардал 3,254.6 мянган төгрөгийг суутгаж 607,254.4 мянган төгрөгийг шилжүүлсэн бөгөөд хөрөнгө оруулалтын гүйцэтгэлд хяналт хийх нь зүйтэй.

5. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 40,726.9 мянган төгрөгийн 2 алдаа, зөрчил илэрснийг санхүүгийн тайланд залруулж, 9,307.0 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргуулахгүй байх 2 зөвлөмж өгсөн.

Залруулсан алдаа

1. Санхүүгийн байдлын тайлангийн мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдлийг 147.6 мянган төгрөгөөр илүү тайлагнасан байсныг санхүүгийн тайланд залруулав.

2. Дэлхийн банк, Азийн хөгжлийн банкны урт хугацаат зээлийн 2023 онд төлөгдөх 40,579.3 мянган төгрөгийг богино хугацаат өр төлбөрөөр тайлагнасныг санхүүгийн тайланд залруулав.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төсвийн хэмнэлт, үр ашигтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Байгууллагын хамтын гэрээний 3.12в-д "Түлш эрчим хүчний тэргүүний ажилтан болон тус байгууллагад ажиллаж байгаа бусад салбарын тэргүүний ажилтанд 5.000, хөдөлмөрийн хүндэт медальтанд 7000, алтан гадас одонд 10000, хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонд 12000, гавьяатад 17000, хөдөлмөрийн баатарт 22000 төгрөг сар бүр олгоно. Тэтгэвэрт гарсан тэргүүний ажилтан, гавьяат төрийн шагналтан, хөдөлмөрийн баатар энэ заалтад нэгэн адил хамаарна" гэсэн заалтын дагуу албан

хаагчдад шагналын дагалдах шагналд 2,007.0 мянга, ахмад настанд 3.444.0 мянга, нийт 5,451.0 мянган төгрөгийг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 42 дугаар зүйлийн 41.2.2 дахь “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах”, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.6 дахь “төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлийн санхүүжилтийг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гэрээ, төлбөрийн хуваарийг үндэслэн санхүүжүүлэх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтыг тус тус зөрчсөн санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хамтын гэрээг хууль, тогтоомжид нийцүүлэн дахин боловсруулах зөвлөмж өгөв.

2. Зардлын холбоотой асуудал

Илрүүлэлт: Захирлын 2022.03.04-ний өдрийн 37 дугаар тушаалаар эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөрт зориулж гарын бэлэгт 23 албан 920.0 мянган төгрөгийн бэлэг дурсгалын зүйл худалдан авсан, 2022.03.04-ний өдрийн 40 дугаар тушаалаар байгууллагын аварга шалгаруулах сагсан бөмбөгийн тэмцээний зардалд 236.0 мянга, 2022.03.15-ны өдрийн 50 дугаар тушаалаар Дэлхийн усны өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх тэмцээний зардалд 500.0 мянга, 2022.04.25 өдрийн 79 дүгээр тушаалаар сагсан бөмбөгийн тэмцээний зардалд 800,0 мянга, 2022.05.18-ны өдрийн 88 дугаар тушаалаар Хүүхдийн эрхийг хамгаалах өдрийн хүнсний зардалд 1,400.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 42 дугаар зүйлийн 41.2.2 дахь “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Санхүүгийн байдлын тайлангийн мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдлийг 147,558.58 төгрөгөөр илүү тайлагнасан байна.	1	147.6	1	147.6			1	147.6				
Дэлхийн банк, Азийн хөгжлийн банкны урт хугацаат зээлийн 2023 онд төлөгдөх 40,579.3 мянган төгрөгийг богино хугацаат өр төлбөрөөр тайлагнасныг санхүүгийн тайланд залруулав.	1	40,579.3	1	40,579.3			1	40,579.3				
Дүн	2	40,726.9	2	40,726.9	0	0	2	40,726.9	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Хамтын гэрээний 3.12в-д "Түлш эрчим хүчний тэргүүний ажилтан болон тус байгууллагад ажиллаж байгаа бусад салбарын тэргүүний ажилтанд 5.000, хөдөлмөрийн хүндэт медальтанд 7000, алтан гадас одонд 10000, хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонд 12000, гавьяатад 17000, хөдөлмөрийн баатарт 22000 төгрөг сар бүр олгоно. Тэтгэвэрт гарсан	1	5,451.0					1	5,451.0				

тэргүүний ажилтан, гавьяат төрийн шагналтан, хөдөлмөрийн баатар энэ заалтад нэгэн адил хамаарна" гэсэн заалтын дагуу албан хаагчдын тэмдэгний мөнгөнд 2,007.0 мянга, ахмад настны тэмдэгний мөнгөнд 3.444.0 мянга, нийт 5,451.0 мянган төгрөгийг олгосон байна.												
Захирлын 2022 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 37 тоот тушаалаар эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөрт зориулж гарын бэлгэнд 23 албан хаагчид нэг бүр нь 40.0 мянган төгрөгийн үнэ бүхий нийт 920.0 мянган төгрөгийн бэлэг дурсгалын зүйл худалдан авсан, 2022 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 40 тоот тушаалаар байгууллагын аварга шалгаруулах сагсан бөмбөгийн тэмцээний зардалд 236.0 мянга, 2022 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 50 тоот тушаалаар Дэлхийн усны өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх тэмцээний зардалд 500.0 мянга, 2022 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 79 тоот тушаалаар сагсан бөмбөгийн тэмцээний зардалд 800,0 мянга, 2022 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 88 тоот тушаалаар Хүүхдийн эрхийг хамгаалах өдрийн хүнсний зардалд 1,400.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.	1	3,856.0					1	3,856.0				
Дүн	2	9,307.0	0	0	0	0	2	9,307.0	0	0	0	0

_____oOo_____